

БАТЛАВ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУДЧДАЛЫН ГАЗРЫН
ДАРГА



2019 оны 09 сарын 27 өдөр

ЦЭРГИЙН АЛДАР ХӨШӨӨНИЙ МОДЛОГ УРГАМЛЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ХАМГААЛАЛТЫН ХАШААНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалт/
гэрээний нэр, дугаар:

“Цэргийн алдар” хөшөөний модлог
ургамлын цэцэрлэгийн
хамгаалалтын хашаа,
ГСАОНӨГ/201907066

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос “Цэргийн алдар” хөшөөний модлог ургамлын цэцэрлэгийн хамгаалалтын хашааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг *2019 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 11 цагаас өмнө битүүмжилсэн цахим тендер ирүүлэхийг урьж байна.*

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан *2019 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 11 цаг 30 минутад* нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. “Тооцно”

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг,
Нутгийн удирдлагын ордон, 3-р давхар,
309 тоот өрөө, Орон нутгийн өмчийн газрын
Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн , 70543033**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
- 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
 - 1.2. Тендерт оролцогч тухайн үйлчилгээнд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: **ТШӨХ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ-д заасан**
 - 1.3. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг үйлчилгээ үзүүлэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: **ТШӨХ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ-д заасан**
- 2. Тендериин иж бүрдэл**
- 2.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үйл ажиллагааны хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) Ирүүлсэн баримт бичгүүдийн товьёог /Баримт бичиг нь нүүр хуудастай, хуудсыг дугаарласан байна. Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул Тендерт оролцогч нь цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д өөрийн аж ахуйн нэгжийн үндэсний тоон гарын үсэгийн гэрчилгээг ашиглан хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендериийн материалыа цахим /1 PDF файлд оруулсан / хэлбэрээр ирүүлнэ.
- 3. Тендериин үнэ**
- 3.1. Тендериин үнэд тодорхойлсон нийт үйлчилгээ хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үйл ажиллагааны хуваарьт үндэслэнэ.
 - 3.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 3.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон үйл ажиллагааны хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 3.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстай бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендериийн нийт үнэд багтаасан байна.

- | | |
|--|---|
| 4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | <p>4.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш [4]¹ хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p> |
| 5. Алдааг залруулах | <p>5.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:</p> <ul style="list-style-type: none"> (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ; (б) үйл ажиллагааны үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үйл ажиллагааны үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна; (в) нэгж үнийг үйлчилгээний тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна. <p>5.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.</p> |
| 6. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | <p>6.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>6.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> |
| 7. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | <p>7.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p> |

¹ Энэ нь үнийн саналыг үнэлэх, гэрээ байгуулахад хүрэлцэхүйц (жишээлбэл хоног) хугацаа байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГД ОХ ЗААЛТ	Шалгур үзүүлэлт																
ТОӨЗ 1.1	<p>1. Улсын бүртгэлийн гэрчилгээ /хуулбарыг наториатоор гэрчилүүлж ирүүлэх/</p> <p>2. Татварын албаны тодорхойлолт /татварын өргүй тухай/</p> <p>3. Харилцагч банкны тодорхойлолт /өр, зээлийн тухай /</p> <p>4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт</p> <p>5. Захиалагчаас тендерт оролцогчийн харилцагч банк, харьяалах татвар болон санхүүгийн байгууллагуудаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл /Дээрхи тодорхойлолтуудыг эх хувиар нь тус тендер зарлагдсанаас хойши хугацаагаар гаргаж захиалагчийн нэр дээр ирүүлнэ./</p> <p>6. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлд хийсэн ижил төстэй ажлууд</p> <p>/Загвар хүснэгтийн дагуу ирүүлнэ/</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Гэрээн ий дугаар</th> <th>Захиалагч, үйлчлүүлэг чийн нэр, холбоо барих ажилтан, утасны дугаар</th> <th>Гүйцэтгэс эн ажлын нэр, дууссан он</th> <th>Гэрээний үнэ</th> <th>Ерөнхий /түншлэл/ туслан гүйцэтгэгчээр ажилласан эсэх</th> </tr> </thead> <tbody> <tr> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table> <p>Сүүлд хийсэн ижил төстэй ажлын гэрээ, дуусаагүй бол дуусаагүй ажлын шалтгааныг тайлбарлах ба тухайн захиалагчийн тодорхойлолтыг ирүүлэх. /Ижил төстэй ажил гэдэгт гадна тохижилт болон хашааны ажлыг тооцно./</p> <p>7. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: [БА 8.1- Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил]</p> <p>Барилга угсралтын тусгай зөвшөөрлийн хуулбар, гэрээний хамт /хуулбарыг наториатоор гэрчилүүлж ирүүлэх/</p> <p>/Хуучин тусгай зөвшөөрөлтэй дүйцүүлэх ба сунгаж байгаа болон хугацаа нь дууссан тусгай зөвшөөрлийг тооцохгүй болно./</p> <p>8. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: [тоног төхөөрөмжийг жагсаана]</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Машин, механизм тоног төхөөрөмжийн нэр</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Автомашин</td> </tr> </tbody> </table>	№	Гэрээн ий дугаар	Захиалагч, үйлчлүүлэг чийн нэр, холбоо барих ажилтан, утасны дугаар	Гүйцэтгэс эн ажлын нэр, дууссан он	Гэрээний үнэ	Ерөнхий /түншлэл/ туслан гүйцэтгэгчээр ажилласан эсэх							№	Машин, механизм тоног төхөөрөмжийн нэр	1	Автомашин
№	Гэрээн ий дугаар	Захиалагч, үйлчлүүлэг чийн нэр, холбоо барих ажилтан, утасны дугаар	Гүйцэтгэс эн ажлын нэр, дууссан он	Гэрээний үнэ	Ерөнхий /түншлэл/ туслан гүйцэтгэгчээр ажилласан эсэх												
№	Машин, механизм тоног төхөөрөмжийн нэр																
1	Автомашин																

		<table border="1"> <tr> <td>2</td><td>Гагнуурын аппарат</td><td></td></tr> <tr> <td>3</td><td>Бусад тоног төхөөрөмж</td><td>Г.М</td></tr> </table>	2	Гагнуурын аппарат		3	Бусад тоног төхөөрөмж	Г.М	
2	Гагнуурын аппарат								
3	Бусад тоног төхөөрөмж	Г.М							
/Гэрчилгээний хуулбарыг ирүүлэх ба түрээслэх бол түрээсийн гэрээг ирүүлнэ./									
9. Гагнуурчнаар томилсон тухай захирлын тушаал, мэргэжлийн үнэмлэх, цахим үнэмлэхний хуулбар ирүүлэх.									
10. Захиалагчийн хяналтын зардал, татвар хураамжийг холбогдох хуулийн дагуу тус тус тооцож, барилгын засварын ажлын төсвийг мэргэжлийн мэргэшсэн төсөвчнөөр хийлгэж гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулсан байна.									
11. Үнэлсэн үе шатны ажлын хуваарь, ажил гүйцэтгэх технологи аргачлал, ажлын графикийг гаргаж гарын үсэг, тамга тэмдэгээр баталгаажуулан ирүүлнэ.									
12. Тендерийн баримт бичгийн 5, 6-р бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг зөвшөөрч байгаа талаар албан мэдэгдэл ирүүлнэ.									
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг, Нутгийн удирдлагын ордон, Орон нутгийн өмчийн газар</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 3-р давхар, 309 тоот</p> <p>Огноо: 2019 оны 10-р сарын 04-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 00 минут</p>								
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг, Нутгийн удирдлагын ордон</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Орон нутгийн өмчийн газар, 3-р давхар, 309 тоот</p> <p>Огноо: 2019 оны 10-р сарын 04-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 30 минут</p>								
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>“Цэргийн алдар” хөшөөний модлог ургамлын цэцэрлэгийн хамгаалалтын хашаа- ГСАОНӨГ/201907066</p>								

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**БАТЛАВ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА**
Д.МОНХ-ЭРДЭНЭ



2019 оны 09. сарын 27. өдөр

“ЦЭРГИЙН АЛДАР”ХӨШӨӨНИЙ МОДЛОГ УРГАМЛЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ХАМГААЛАЛТЫН ХАШАА, ХАЙС ХИЙХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ


Ажил гүйцэтгэх байршил: Говьсүмбэр аймгийн төв Сүмбэр сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Цэргийн алдар”ын цэцэрлэгийн хамгаалалтын хашаа.

№	Үзүүлэлт	Шалгуур
1	Ерөнхий шаардлага	“Цэргийн алдар хөшөөний ногоон байгууламжийг хамгаалах хашааны ажлыг гүйцэтгэхдээ барилгын болон аюулгүй ажиллагааны холбогдох дүрэм журам, стандартыг чанд баримталж захиалагч талтай нягт хамтран ажиллаж, хийгдэх ажлын тоо хэмжээг нарийн баримталж, чанарын шаардлагыг эрхэмлэн ажиллах.
2	Гүйцэтгэгчид тавих шаардлага	Хашааны төмөр хийцийн болон угсралтын ажлыг гүйцэтгэх чадвартай мэргэжлийн гагнуурчин болон ажилчидтай, өмнө нь тус ажилттай ижил төрлийн 2 доошгүй ажил гүйцэтгэж байсан дадлага туршлагатай байх.
	Ажлын даалгавар	<ul style="list-style-type: none"> • Сүмбэр сумын иргэдийг ая тухтай орчин, ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх үүднээс цэргийн алдын хөшөөт цогцолборын бичил цэцэрлэг байгуулах ажил хийгдэх учир түүнийг хамгаалсан нэг загварын хашаа хайс барина. • Хашаа нь тэгш өнцөгт ба нийт 560 метр газарт хамгаалалтын хашаа хайс чанартай хийсэн байх. • Хашаа хайс нь 1.1 метрийн өндөртэй 2 метрийн урттай гаднын нөлөө, мал, амьтнаас хамгаалсан байх. • Хамгаалалтын хашаа нь хотын өнгө үзэмжид нийцэхүйц, хүүхэд багачууд гэмтэж бэртэхээс сэргийлсэн, бат бөх шинэ төмөр материалыар хийгдэж элэгдэлд тэсвэртэй төмрийн зориулалтын будгаар өнгө ялган будсан байна. • Том хаалга нь 4 м урттай ба хашаатайгаа ижил түвшинд байх. • Хашааг гангийн орцтой чанарын шаардлага хангасан шинэ квадрат төмөр материалыар хийх ба төмрийн зузаан 1.5 мм багагүй, шонгийн суурийг газарт бэхлэн

		40 см гүнд цемент цутгаж хийнэ. /Энэ нь газрын гадаргууын тэгш бус байдлаас хамаарч хашааны ерөнхий түвшинг гаргахын тулд шонгийн өндөр, болон хөрсөнд суултын хэмжээ тухайн тохиолдолд нэмэгдэж болно/ Мөн газарт суух 40 см шонгийн хөлний доод талд хөндлөн тээглүүр заавал хийнэ.
	Тоо хэмжээ	<ul style="list-style-type: none"> Хашааны шон 1.5 метр өндөртэй, 560 метр урт хамгаалалтын хашаа хайс хийсэн байх. /багана болгон дээр гоёл байх/ 40*40 харьцаатай метр квадрат төмрөөр суурь багана хийх. /420 метр урт квадрат төмөр орно/ 40*20 харьцаатай метр квадрат төмрөөр нэг хашаанд 2 ширхэг хөндлөлтэй байх ба дээд хөндлөн хашааны оройгоос 10 см, доод хөндлөн газарт суусан хөлөөс дээш 10 см байх. /1120 метр урт квадрат төмөр орно/ Хашааны савх 20*20 харьцаатай метр квадрат төмрөөр нэг хашаанд 15 ширхэг савхан орох ба хооронд 13 см зйтай байх. /4620 метр урт квадрат төмөр орно/

Зураг: Хашааны загварын зураг

1.1 м өндөртэй, 2 м урттай нэг хашааны тооцоо



Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хөвтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарын заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарын хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өргтийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарын заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарын заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарын зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гол түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------------------------------|---|
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтооходоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

- | | |
|---|---|
| 10. Зөрчил,
гологдол
арилгахгүй
байх | <p>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.</p> <p>10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардлагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.</p> |
|---|---|

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- | | |
|---|--|
| 11. Үе шатны
ажлын
хуваарь | <p>11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.</p> <p>11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.</p> |
| 12. Үе шатны
ажлын
хуваарийг
өөрчлөх | <p>12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.</p> |
| 13. Алданги | <p>13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.</p> |

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- | | |
|------------------------------|--|
| 14. Ажил
дуусгах | <p>14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.</p> |
| 15. Хүлээж авах | <p>15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.</p> |
| 16. Эцсийн
тооцоо | <p>16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусгахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор</p> |

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

- | | |
|--|---|
| 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага | <p>17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.</p> <p>17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.</p> |
| 18. Гэрээг цуцлах | <p>18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.</p> <p>18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none">(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон. <p>18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.</p> |
| 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр | <p>19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон</p> |

өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх** 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Сүмбэр сумын 2-р багт хийгдэх “Нэгдсэн эмнэлгийн барилгын газардуулга, генераторын барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/” Дугаар: ГСАОНӨГ/201907066
ГЕН 2.1	Ажил нь: Сүмбэр сумын 3-р багт хийгдэх “Цэргийн алдар” хөшөөний модлог ургамлын цэцэрлэгийн хамгаалалтын хашаа -аас бүрдэнэ. Ажлын талбай нь Сүмбэр сум 3-р баг -д байршил ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Д.Мөнх-Эрдэнэ
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр: Гэрээнд заасан хугацаанд Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: 2019 оны ..-р сарын ..-ний өдөр
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 1 жил байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гүйцэтгээгүй үүргийн 0,5 хувь байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувь байна.
ГЕН 17.1	Гүйцэтгэлийн зургийг ажил хүлээлцэхээс 5 хоногийн өмнө гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд сутгах төлбөрийн хэмжээ 500,0 мянган төгрөг байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 0 хувь -иар тооцно.

НЭМЭЛТ НӨХЦӨЛ

- Гэрээт ажлыг тендерийн баримт бичигт санал болгосон өөрийн ажиллах хүчээр гүйцэтгүүлэх ба туслах ажилчдын 70 хувийг аймгийн Хөдөлмөрийн халамжийн үйлчилгээний газарт бүртгэгдсэн ажилгүйчүүдийг авч ажиллуулах
- Гэрээт ажлыг бусдад шилжүүлсэн тохиолдолд тухайн орон нутгаас зарласан дараагийн тендерт оролцуулахгүй болно.
- Тендерт өгөгдсөн ажлын тоо хэмжээнээс гадна хийсэн ажлыг санхүүжүүлэхгүй.
- Ажилд хэрэглэгдэж буй бараа материалын лаботорийн шинжилгээ, сертификатыг ажлын талбайд байлгах.
- Далд ажлын актыг тухайн ажлыг хийж дуусмагц захиалагчийн хяналтын инженерийг газар дээр нь үзүүлж баталгаажуулна.
- Тухайн ажлыг гүйцэтгэж байгаа байгууллага, ашиглалтад өгөх хугацаа зэрэг мэдээллийг багтаасан мэдээллийн самбарыг хүнд харагдахуйц хэлбэрээр ажлын талбайд байршуулна
- Гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлтийг харгалзан Тендерийн баримт бичгийн 7 дугаар зүйлд заасан маягтын дагуу гаргасан Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн арилжааны банкнаас ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн гэрээний үнийн дүнгийн 30 хүртэлх хувийн урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэгчид олгож болно. Ажлын явцад үе шатны гүйцэтгэлээр 40 хувийг санхүүжүүлэх ба ажил дуусч улсын комисст хүлээлгэн өгсөн актыг үндэслэн үлдэгдэл хувийн санхүүжилтийг олгоно.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хүчилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :

- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний өрөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]